



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 3 сарын 6 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орхон аймгийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчид, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн
Удирдлага, төлөөллийн албаны дарга;

Гишүүд:

А.Молор

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн.

Б.Амарбаясгалан

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн.

Г.Нямдаваа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн.

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3.Албан хаагчдын томилолтын зардлын төсвийг 02 дугаар хавсралтаар баталсугай.

4.Албан хаагчийн унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

5.Томилолтоор ажилласан ажлын тайланг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан танилцуулахыг Ажлын хэсэг / В.Дарханбаатар /-т даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013892

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

1.1. Орхон аймгийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчид, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

Дараах чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, сургалт зохион байгуулна.
Үүнд:


- 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн удирдлага, арга зүйн талаар
- 2.2. Компанийн засаглалын олон улсын сайн туршлага ба Төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын өмчлөл, засаглал, үр өгөөжийг сайжруулах асуудлаар;
- 2.3. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах ажлыг сайжруулах асуудлаар;
- 2.4. Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолын хүрээнд хувийн хэвшлээр гүйцэтгүүлсэн ажлын туршлага, кейсийн талаар;
- 2.5. Улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан туршлага, кейсийн талаар;
- 2.6. Компанийн засаглалын кодекс;
- 2.7. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөл, засаглалын талаар оролцоонд суурилсан сургалт /workshop/ зохион байгуулах;
- 2.8. Орхон аймгийн орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын нөхцөл байдалтай танилцаж, санал солилцон, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

Гурав: Үр дүн, хугацаа

3.1. Ажлын хэсэг томиолтоор ажилласан ажлын тайланг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагад танилцуулах.

.....000.....

Төрийн өмчийн бодолго, зохицуулалтын
газрын даргын 2024 оны 03 дугаар сарын
06 өдрийн 15 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ УДИРДАМЖ,
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Нэг. Албан томилолтоор ажиллах хугацаа:

2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс ажлын 2 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

Нэг. Албан томилолтоор ажиллах бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:
ТӨУЗХ-ийн УТАлбаны дарга В.Дарханбаатар

Гишүүд:
ТӨУЗХ-ийн мэргэжилтэн А.Молор
ТӨУЗХ-ийн мэргэжилтэн Б.Амарбаясгалан
ТӨУЗХ-ийн мэргэжилтэн Г.Нямдаваа

Жолооч: Х.Базаррагчаа

Хоёр. Зардлын төсөв

д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөг/
	Тээврийн зардал / 100 км-т 20 л Бензин/А-92/, 1л шатахуун хөдөө орон нутагт 2500 төг/ Томиллолт 5 албан хаагч 2 хоног 1 машин.	
1	Унааны зардал: Орхон аймаг, Эрдэнэт хот явах, ирэх унааны зардал /390*2=780км/ 7.8 х 2500 х 20=390,000.00 төгрөг	390,000.00
2	Байр: 5 хүн х 2 хоног х 110 000= 1,100,000.00 Хоол: 5 хүн х 2 хоног х 32 000= 320,000.00	1,420,000.00
	Нийт дүн:	1,810,000.00

Тоогоор /1,810,000.00 төгрөг/, үсгээр /нэг сая найман зуун арван мянга/ төгрөг.

Тайлбар: Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалаар батлагдсан томилолтын зардлын нормативыг үндэслэн тооцов.

.....000.....